



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/08

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Үндсэн хөрөнгө акталж данснаас
хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3 дахь заалтууд, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар хурлын 13 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын А/224 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 76 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 1910000 (Нэг сая есөн зуун арван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий үлдэх өртөггүй тракторыг үндсэн хөрөнгийн данснаас хассугай.

2. 1910000 (Нэг сая есөн зуун арван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий үлдэх өртөггүй тракторыг үндсэн хөрөнгийн данснаас хасахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр), нярав (Н.Ганцэцэг) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОТГОНБАЯР